



ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2020 оны 05 сарын 29 өдөр

Дугаар А/227

Арвайхээр


Хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, 29.1.5. "а", Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2019 оны 12/02 дугаар тогтоолоор батлагдсан "Өвөрхангай аймгийн эдийн засаг, нийгмийг 2020 онд хөгжүүлэх үндсэн чиглэл"-ийн 3.2.9.65 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Гучин-Ус сумын Цэцэрлэг, Ерөнхий боловсролын сургуульд зөөврийн компьютер, хивс, дрож авах зардалд 10,000,000 (арван сая) төгрөгийг зарцуулсугай.

2. Дээрх зардлыг аймгийн эдийн засаг, нийгмийг 2020 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийг хэрэгжүүлэх зардлаас санхүүжүүлэхийг аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтэс (Д.Нэмэхбаяр)-т зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА



Г.ГАНБОЛД

011100481